



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/00

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын ухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2 дахь заалт, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх, үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Аюушжав-Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч  
Гишүүд: Ш.Бумандолгор- Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн  
Д.Энх-Амгалан-Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн ахмад  
Н.Батсайхан-Татварын улсын байцаагч  
Г.Ганчимэд-Эрүүл мэндийн төвийн Нийгмийн ажилтан  
Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга  
С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга

2. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд ариутгал, халдваргүйтгэлийн дэглэмд хяналт шалгалт хийх, зөрчлийг арилгуулах.

б. Хүнс үйлдвэрлэлийн болон худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мөрдөж буй тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг удирдамжийн дагуу шалгаж, үүрэг даалгавар өгөх.

в. Дээрх төлөвлөгөөт бүхий шалгалтын үр дүнгийн талаар сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулахыг ажлын хэсэг (П.Аюушжав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051# 010039